


Ипотекийн зээлийн дэлгэрэнгүй тайлан 2016 оны 8 дугаар сар

1. Ипотекийн зээлийн үлдэгдэл

Банкууд 2016 оны 8 дугаар сард нийт 1299 зээлдэгчид 75.5 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноор ипотекийн зээлийн үлдэгдэл 3893.5 тэрбум төгрөг, нийт зээлдэгчдийн тоо 86221-д хүрчээ.


Тайлант сарын эцэст ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт өмнөх сартай харьцуулахад 0.2 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 8.7 нэгж хувиар буурч 19.2 хувь болсон байна.

Зураг 1. Ипотекийн зээлийн үлдэгдэл болон сарын өсөлт



Тайлант сарын эцэст ипотекийн зээлийн үлдэгдлийн 77.8 хувь буюу 3029.6 тэрбум төгрөгийг “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл, 20.6 хувь буюу 803.1 тэрбум төгрөгийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 1.6 хувь буюу 60.7 тэрбум төгрөгийг бусад эх үүсвэрээр олгосон зээл бүрдүүлж байна.

Зураг 2. Ипотекийн зээлийн үлдэгдэл, эх үүсвэрээр



2016 оны 8 дугаар сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 99% нь төгрөгийн зээл, 1% нь валютын зээл байна.

Ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хугацаа хэтэрсэн зээл 2016 оны 8 дугаар сарын байдлаар 3.3 хувь, чанаргүй зээл 1.3 хувь байна.


Зураг 4. Ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хувь



2. Тайлант сард олгосон ипотекийн зээл


Тухайн сард олгосон ипотекийн зээл өмнөх сараас 18.7 хувиар буурсан бол өмнөх оны мөн үеэс 24.0 хувиар өссөн байна.

Зураг 7. Тухайн сард олгосон зээл



Тайлант сард шинээр олгосон зээлийн 76.7 хувь буюу 57.9 тэрбум төгрөг нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл, 23.3 хувь буюу 17.6 тэрбум төгрөг нь банкуудын өөрийн эх үүсвэрээс олгосон зээл байна.


Зураг 9. Нэг хүнд ногдох тухайн сард олгосон зээл



Нэг зээлдэгчид ногдох олгосон зээлийн хэмжээ 2016 оны 8 дугаар сарын байдлаар 58.1 сая төгрөг байна.

Тухайн сард 41.0 тэрбум төгрөгийн ипотекийн зээл төлөгдсөн нь өмнөх оны мөн үеэс 68.4 хувиар, өмнөх сараас 8.5 хувиар тус тус өссөн байна.

Зураг 10. Тухайн сард шинээр олгосон болон төлөгдсөн зээл



3.3. Зээлдэгчдийн тоо


Тайлант сард нийт 1299 зээлдэгч шинээр ипотекийн зээлд хамрагдсанаас 967 зээлдэгч “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 332 зээлдэгч банкны өөрийн эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.

Зураг 11. Тухайн сард зээл авсан зээлдэгчдийн тоо болон сарын өсөлт



2016 оны 8 дугаар сарын байдлаар нийт 86221 иргэн ипотекийн зээлтэй байгаагаас 63729 нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 20635 нь банкуудын өөрийн эх үүсвэрийн зээлд, 1857 нь бусад эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.

Зураг 12. Нийт зээлдэгчдийн тоо болон сарын өсөлт




4. Ипотекийн зээлийн хугацаа

Тайлант сард банкууд 3 сараас 30 жилийн хугацаатай зээл олгосон бөгөөд жигнэсэн дундаж хугацаа нь 19.0 жил байна. Ипотекийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хугацаа 2016 оны 8 дугаар сарын байдлаар 16.4 жил байна.

Тухайн сард олгосон зээлийн дийлэнх буюу 37.6 хувь нь 16-20 жилийн хугацаатайгаар олгогдсон байна. Харин нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 71.9 хувь нь 16-20 жил, 17.0 хувь нь 11-15 жил, 9.1 хувь нь 6-10 жил, 1.6 хувь нь 1-5 жилийн хугацаатай байна.


Зураг 13. Ипотекийн зээл, хугацааны ангилалаар



5. Ипотекийн зээлийн хүү

Банкуудын 2016 оны 8 дугаар сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 8.41 хувь байна. “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр” хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад жигнэсэн дундаж хүү 8.2 нэгж хувиар буурсан байна.

Зураг 15. Тухайн сард олгосон зээлийн ЖДХүү



Банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 12.9 хувь байв.

Хавсралт 1-д Банкуудын ипотекийн зээлийн нэгдсэн тайланг харуулав.

Он	Сар	Ипотекийн зээлийн үлдэгдэл (сая төг.)	Үүнээс:		Тайлант сард шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа (жилээр)	Тухайн сард олгосон зээлийн жилийн ЖДХүү, (%)	Нийт зээлдэгч (тоогоор)	Үүнээс:	
			ОСИССТБ хөтөлбөрийн зээл					ОСИССТБ хөтөлбөрийн зээлтэй	
2008	12	217,977.5			8.4	19.8	16,522		
2009	12	226,040.6			8.6	18.7	16,784		
2010	12	333,776.6			9.6	16.0	16,700		
2011	12	669,662.8			12.9	14.8	26,869		
2012	12	845,204.4			13.0	15.3	29,887		
2013	12	1,938,945.3	1,248,633.8		16.1	9.9	48,320	30,600	
2014	1	2,021,424.9	1,324,898.9		16.2	9.8	49,731	32,190	
	2	2,121,802.6	1,382,084.1		16.1	9.9	53,611	33,346	
	3	2,193,368.6	1,451,938.1		15.9	9.9	54,787	34,632	
	4	2,280,503.5	1,538,506.8		16.0	9.8	56,137	36,081	
	5	2,365,349.5	1,618,127.2		15.8	10.0	57,579	37,488	
	6	2,440,007.1	1,684,583.9		15.2	10.5	58,793	38,659	
	7	2,492,105.2	1,728,222.8		15.7	10.7	59,756	39,507	
	8	2,553,827.2	1,780,078.3		15.6	10.5	60,851	40,405	
	9	2,619,161.1	1,833,494.0		15.5	10.6	62,017	41,390	
	10	2,703,792.6	1,903,636.6		15.8	10.4	63,652	42,772	
	11	2,762,726.8	1,954,341.3		16.2	10.3	64,577	43,621	
	12	2,844,706.3	2,027,952.9		16.7	9.9	66,334	45,283	
2015	1	2,898,731.0	2,072,894.5		16.3	10.2	67,233	46,134	
	2	2,949,116.5	2,121,339.7		16.6	9.7	68,126	47,108	
	3	3,015,535.1	2,196,795.5		16.5	9.2	69,269	48,512	
	4	3,082,551.7	2,263,794.5		16.6	9.6	70,498	49,691	
	5	3,128,182.4	2,305,308.1		16.4	10.3	71,355	50,462	
	6	3,192,029.1	2,363,999.7		16.4	9.6	72,412	51,438	
	7	3,230,507.8	2,400,625.2		16.1	9.9	73,208	52,181	
	8	3,267,175.5	2,433,968.6		16.3	10.0	73,949	52,858	
	9	3,319,711.8	2,481,556.8		16.2	9.6	74,848	53,643	
	10	3,370,510.2	2,534,505.4		16.8	9.4	75,877	54,612	
	11	3,412,929.6	2,570,150.9		16.4	10.0	76,583	55,295	
	12	3,432,957.6	2,590,987.6		16.7	8.8	77,105	55,830	
2016	1	3,434,849.9	2,595,234.1		16.3	10.1	77,226	56,031	
	2	3,459,596.6	2,623,837.0		16.6	9.2	77,673	56,577	
	3	3,565,321.5	2,679,829.3		17.1	8.8	81,015	57,659	
	4	3,632,982.1	2,751,292.4		16.1	8.2	82,320	59,001	
	5	3,704,168.2	2,832,261.7		16.2	8.3	83,280	60,455	
	6	3,799,387.7	2,929,375.2		16.4	7.7	84,906	62,080	
	7	3,856,332.4	2,995,847.0		16.3	7.7	85,622	63,146	
	8	3,893,474.3	3,029,623.4		16.4	8.4	86,221	63,729	

Хавсралт 2. Орон нутгийн банкуудын ипотекийн зээлийн тайлан

2016 оны 8 дугаар сарын байдлаар

Аймгууд	Ипотекийн зээлийн		Үүнээс ОСИСТБХ-ийн зээл		Тухайн сард олгосон ипотекийн зээлийн жилийн ЖДХугацаа (жилээр)	Тухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХүү (жилээр)	Нийт зээлдэгчдийн тоо	Үүнээс: ОСИСТБХ хөтөлбөрийн зээлтэй
	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь				
1 Улаанбаатар	2,980,532.9	76.6%	2,298,749.5	75.9%	198.0	8.7	57924	44,174
2 Орхон	127,106.4	3.3%	113,868.9	3.8%	153.1	6.5	3231	2,760
3 Дархан-Уул	126,239.0	3.2%	113,385.2	3.7%	257.5	6.3	3662	3,135
4 Дорноговь	79,606.7	2.0%	66,876.8	2.2%	186.3	6.4	2289	1,813
5 Дорнод	58,058.4	1.5%	53,142.7	1.8%	226.2	7.5	1847	1,590
6 Увс	52,798.8	1.4%	37,873.7	1.3%	172.7	8.0	1685	890
7 Сэлэнгэ	50,105.1	1.3%	38,637.8	1.3%	135.7	7.8	1700	1,156
8 Өвөрхангай	47,911.1	1.2%	35,062.0	1.2%	162.9	11.1	1676	915
9 Ховд	45,498.5	1.2%	38,242.2	1.3%	245.9	5.4	1429	1,063
10 Өмнөговь	45,439.8	1.2%	35,503.3	1.2%	184.4	8.6	1253	879
11 Баянхонгор	33,798.1	0.9%	28,005.6	0.9%	191.7	5.7	1061	784
12 Сүхбаатар	32,221.2	0.8%	23,933.7	0.8%	208.0	10.2	1058	652
13 Архангай	29,524.5	0.8%	22,904.9	0.8%	200.2	8.7	853	560
14 Баян-Өлгий	26,060.6	0.7%	14,446.0	0.5%	149.5	12.5	1175	393
15 Хөвсгөл	24,041.5	0.6%	13,274.1	0.4%	200.2	7.8	920	304
16 Завхан	22,814.4	0.6%	14,020.2	0.5%	131.0	9.6	808	346
17 Говь-Алтай	22,781.5	0.6%	17,721.8	0.6%	148.1	6.5	742	524
18 Хэнтий	22,211.3	0.6%	18,123.0	0.6%	185.1	6.4	657	485
19 Төв	19,618.7	0.5%	12,699.7	0.4%	152.4	6.9	615	348
20 Дундговь	17,951.6	0.5%	13,295.4	0.4%	157.8	6.7	586	379
21 Булган	15,035.4	0.4%	7,714.1	0.3%	145.6	14.2	533	201
22 Говьсүмбэр	14,119.0	0.4%	12,142.9	0.4%	254.4	6.2	517	378
Нийт	3,893,474.3	100.0%	3,029,623.4	100.0%	196.5	8.4	86221	63729

2016 оны 8 дугаар сарын байдлаар банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 76.6 хувийг Улаанбаатар хотод, үлдсэн 23.4 хувийг хөдөө орон нутагт олгосон ипотекийн зээл бүрдүүлжээ. Хөдөө орон нутаг дахь ипотекийн зээлийн үлдэгдлийн 13.9 хувь буюу 127.1 тэрбум төгрөг Орхон аймагт, 13.8 хувь буюу 126.2 тэрбум төгрөг Дархан-Уул аймагт, 8.7 хувь буюу 79.6 тэрбум төгрөг Дорноговь аймагт ногдож байна.